

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Орхон тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2026/14/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
3.1 Төлбөрийн акт	9
3.2 Албан шаардлага	10
3.3 Зөвлөмж	10
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	12

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААТҮГ	Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ОСТҮ	Орхон сумын тохижилт үйлчилгээ



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.13 № 185

талай _____ -ны № _____ -т

“ОРХОН ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ”
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА Б.ХИШИГБУЯН
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Орхон тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант оны орлогын төлөвлөгөөг 909,170.8 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 1,039,735.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн нь 14.3 хувиар давуулан биелүүлсэн байна.

Аудитын гол асуудлууд

Байрны түрээсийн авлага нь 2024 онд үүссэн бөгөөд он дамжсан Орон нутгийн өмчийн газартай байгуулсан гуравласан гэрээний 7.3 дахь заалтын дагуу гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд хоног тутам 0.5 хувь буюу 196.0 мянган төгрөгийн алдангийг нэмж тооцоогүй байна. Мөн дулааны авлага Тэс оргил ХХК-аас өмнөх оны 4,215.8 мянган төгрөгийн авлага он дамжиж, тайлант онд 4,691.3 мянган төгрөгөөр нэмэгдэж нийт 8,907.1 мянган төгрөгийн авлагад тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компанийн жилийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 29 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 100 хувиар тайлагнасныг Орхон сумын засаг даргын тамгын газраас 99.0 хувьтай дүгнэсэн байна.

4526050313

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	608,928.95	104,664.87
1.1.2	Дансны авлага	17,644,967.00	17,290,529.68
1.1.6	Бараа материал	42,015,171.52	94,181,987.80
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	60,269,067.47	111,577,182.35
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,159,946,617.67	2,990,791,816.80
1.2.2	Биет бус хөрөнгө	-	625,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,159,946,617.67	2,991,416,816.80
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,220,215,685.14	3,102,993,999.15
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	-	-
2.1.1.2	Цалингийн өглөг	182,151.00	-
2.1.1.3	Татварын өр	-	1,063,384.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	100,000.00	24,017,140.38
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	282,151.00	25,080,524.38
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	282,151.00	25,080,524.38
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	111,595,600.00	111,595,600.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,349,166,957.59	1,349,166,957.59
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	2,472,960,883.00	2,722,948,383.00
2.3.9	Хуримтлагдсан үр дүн	(713,789,906.45)	(1,105,797,465.82)
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(433,114,269.94)	(726,502,290.45)
2.3.10	Тайлан үеийн үр дүн	(280,675,636.51)	(379,295,175.37)
2.3.12	Эздийн өмчийн дүн	3,219,933,534.14	3,077,913,474.77
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	3,220,215,685.14	3,102,993,999.15

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	598,596,545.86	709,327,205.65
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг (алдагдал)	598,596,545.86	709,327,205.65
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	243,926,000.00	330,407,910.00
9	Борлуулалт, маркетингийн зардал		-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,030,258,367.58	1,385,565,947.18
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(92,939,814.79)	(32,882,766.84)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		(581,577.00)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(280,675,636.51)	(379,295,175.37)
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(280,675,636.51)	(379,295,175.37)
21	Үндсэн хөрөнгө худалдсаны олз (гарз)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(280,675,636.51)	(379,295,175.37)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		-
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	842,522,545.86	1,035,898,700.65
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	111,595,600.00	1,349,166,957.59	2,472,960,883.00	(433,114,269.94)	3,500,609,170.65
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
3	Залруулсан үлдэгдэл	111,595,600.00	1,349,166,957.59	2,472,960,883.00	(433,114,269.94)	3,500,609,170.65
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(280,675,636.51)	(280,675,636.51)
5	Бусад дэлгэрэнгүй орлого					-
6	Өмчид гарсан өөрчлөлт					-
7	Зарласан ногдол ашиг					-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
9	2024 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	111,595,600.00	1,349,166,957.59	2,472,960,883.00	(713,789,906.45)	3,219,933,534.14
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(12,712,384.00)	(12,712,384.00)
11	Залруулсан үлдэгдэл	111,595,600.00	1,349,166,957.59	2,472,960,883.00	(726,502,290.45)	3,207,221,150.14
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(379,295,175.37)	(379,295,175.37)
13	Бусад дэлгэрэнгүй орлого					-
14	Өмчид гарсан өөрчлөлт			249,987,500.00	-	249,987,500.00
15	Зарласан ногдол ашиг				-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
17	2025 оны 12-р сары 31-ний үлдэгдэл	111,595,600.00	1,349,166,957.59	2,722,948,383.00	(1,105,797,465.82)	3,077,913,474.77

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	842,418,550.06	1,024,763,683.97
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	598,492,550.06	694,355,773.97
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	35,010.00
	Буцаан авсан албан татвар	-	-
	Татаас, санхүүжилтийн орлого	243,926,000.00	330,372,900.00
	Бусад мөнгөн орлого	-	-
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	817,559,680.79	988,656,298.05
	Ажиллагчдад төлсөн	367,664,924.09	493,921,419.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	48,957,690.10	62,596,566.15
	Бараа материал худалдан авахад төлсөн	68,726,270.00	56,796,070.00
	Ашиглалтын зардалд төлсөн	72,044,634.60	243,596,635.83
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	193,659,140.00	66,245,000.00
	Хүүний төлбөрт төлсөн	-	-
	Татварын байгууллагад төлсөн	442,500.00	781,500.00
	Даатгалын төлбөрт төлсөн	514,380.00	559,140.00
	Бусад мөнгөн зарлага	65,550,142.00	64,159,967.07
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	24,858,869.27	36,107,385.92
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүний орлого		-
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	25,783,000.00	36,611,650.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	25,783,000.00	36,611,650.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		

2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(25,783,000.00)	(36,611,650.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		-
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(924,130.73)	(504,264.08)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,533,059.68	608,928.95
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	608,928.95	104,664.87

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	2024 оны гүйцэтгэл	Зөрүү			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
Цэвэр бохир усны орлого	22,405,407.00	22,451,052.00	25,423,739.00	2,972,687.00	88.3
Дулаан эрчим хүчний орлого	491,174,876.10	449,624,999.00	595,459,015.35	145,834,016.35	75.5
Хог хаягдлын орлого	20,393,145.00	17,895,000.00	6,761,871.00	(11,133,129.00)	264.6
Байрны түрээсийн орлого	4,895,552.81	4,754,592.00	4,969,675.30	215,083.30	95.7
Татаас санхүүжилтийн орлого	243,926,000.00	330,372,900.00	330,407,910.00	35,010.00	100.0
Техникийн түрээсийн орлого, бусад	59,727,565.00	84,072,263.00	76,712,905.00	(7,359,358.00)	109.6
НИЙТ ОРЛОГЫН ДҮН	842,522,545.91	909,170,806.00	1,039,735,115.65	130,564,309.65	87.4
Цалин хөлс	367,664,924.09	481,445,770.84	493,921,419.00	12,475,648.16	97.5
АО-аас НД-шимтгэлд төлөх зардал	48,957,690.10	54,416,839.93	62,596,566.15	8,179,726.22	86.9
Материалын зардал	81,821,611.00	79,865,026.00	119,384,658.00	39,519,632.00	66.9
Ашиглалтын зардал	209,932,454.60	203,749,745.68	243,596,635.83	39,846,890.15	83.6
Засвар үйлчилгээний зардал	45,324,820.00	53,544,658.55	3,567,000.00	(49,977,658.55)	1,501.1
Ажиллагсадтай холбоотой зардал	7,133,640.00	7,756,510.00	45,396,000.00	37,639,490.00	17.1
Сургалт томилолтын зардал	460,000.00	660,000.00	450,000.00	(210,000.00)	146.7
Элэгдлийн зардал	253,610,968.65	-	458,208,590.87	458,208,590.87	-

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,959,991.00	26,031,280.00	56,374,249.07	30,342,969.07	46.2
Бусад зардал	2,304,550.00	1,701,006.00	1,000,000.00	(701,006.00)	170.1
НИЙТ ЗАРДЛЫН ДҮН	1,071,170,649.44	909,170,837.00	1,484,495,118.92	575,324,281.92	61.2
ОЛЗ ГАРЗЫН ДҮН	-	-	-	-	
НИЙТ АШИГ/АЛДАГДАЛ	-228,648,103.53	-31.00	-129,171,797.23	-239,470,797.23	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн нийт 46,599.1 мянган төгрөгийн дараах 5 алдааг¹ аудитын явцад залруулав. Үүнд:

1. Цэвэрлэх байгууламж 32,266.7 мянган төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, үндсэн хөрөнгөөс бараа материалд шилжүүлсэн 76.1 мянган төгрөг, акталсан 540.0 мянган төгрөг, нийт 32,882.8 мянган төгрөгийг тайлант үеийн элэгдлийн зардлаар бүртгэж тайлагнасныг үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз дансанд шилжүүлэн бүртгэж, орлогын дэлгэрэнгүй тайланг залруулав.
2. Бараа материал хөрөнгийн ангиллаас 3,080.0 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгөд данс хооронд шилжүүлэхдээ орлогын дэлгэрэнгүй тайланд орлого дансаар дамжуулан бүртгэснийг өмнөх үеийн үр дүн дансаар бүртгэн, орлогын дэлгэрэнгүй тайланд залруулгыг хийв.
3. Тайлант хугацааны дулааны төлбөрийн орлогыг 3,836.4 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг орлогын дэлгэрэнгүй тайланд нэмж тусган залруулав.
4. Санхүүгийн байдлын тайланд 939.4 мянган төгрөгийн авлагыг дутуу тусгасныг нэмж залруулав.
5. Санхүүгийн байдлын тайланд өр төлбөрийг 5,860.5 мянган төгрөгөөр дутуу илэрхийлснийг залруулав.

Дээрх илэрсэн алдаанууд нь УСНББОУС 1 "Санхүүгийн тайлагналын толилуулга", санхүүгийн тайлагналын "Үнэлгээ ба хуваарилалт", "Толилуулга" зэрэг батламж мэдэгдлийг хангаагүй тул Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэж заасны дагуу санхүүгийн байдлын тайлан, орлого үр дүнгийн тайлан, эздийн өмчийн тайланд нэмж залруулав.

Мөн аудитаар нийт 25,879.0 мянган төгрөгийн зөрчил²-д 903.2 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 8,907.1 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 16,068.7 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгөв.

3.1 Төлбөрийн акт

1. Байрны түрээсийн авлага нь 2024 онд үүссэн бөгөөд Орон нутгийн өмчийн газартай байгуулсан гуравласан гэрээний 7.3 дахь заалтын дагуу гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд хоног тутам 0.5 хувь буюу 196.0 мянган төгрөгийн алдангийг нэмж тооцоогүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4-д "Төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

- бүрэлдэхүүн байх", 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах" гэж заасантай тус тус нийцээгүй тул төлбөрийн акт тогтоов.
2. Байгууллагын ажилчдын хүүхдийн бэлэг худалдан авахад зориулж 707.2 мянган төгрөгийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д "Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж заасантай тус тус нийцээгүй тул төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

1. Тэс оргил ХХК-аас авах өмнөх оны 4,215.8 мянган төгрөгийн авлага он дамжиж, тайлант онд 4,691.3 мянган төгрөгөөр нэмэгдэж нийт 8,907.1 мянган төгрөгийн авлагад тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.
2. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй 161,234.1 мянган төгрөгийн нүүрсийг шууд гэрээ байгуулан худалдан авсан нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө", 31 дүгээр зүйлийн 31.1-д "Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна" 44 дүгээр зүйлийн 44.3-т "Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Эзэмшигчийн өмчтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Байгууллагын гэрчилгээ дээрх өмчийн дүн санхүүгийн тайлан дээрх өмчийн дүнгээс 16,068.7 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 болон 13.1 дэх заалтыг баримтлан, улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх дүнгээр санхүүгийн тайлан дахь өмчийн дүнг залруулах ажлыг зохион байгуулах.

2. Гэрээ байгуулахтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Байгууллагын удирдлага нь дээд шатны удирдлагатай бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулаагүй, байгууллагын үр өгөөж, ашгийг дээшлүүлэхэд хариуцлагатай ажиллаагүй нь байгууллагын дүрэмд “Байгууллагын дарга нь Орхон сумын засаг даргатай бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ” байгуулаагүй нь Байгууллагын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.3-т “ОСТУ, ОНӨААТҮГ-ын удирдлага нь Орхон сумын Засаг даргын захирамжаар томилогдсон дарга байх бөгөөд Төсвийн ерөнхийлөн захирагчтай бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулан ажиллана”, 5.5-д “ОСТУ, ОНӨААТҮГ-ын дарга нь энэхүү дүрэм болон сумын Засаг даргатай гэрээ байгуулсан гэрээ, эрх хэмжээний хүрээнд тус байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдана”, 7 дугаар зүйлийн 7.4-т “ ОСТУ, ОНӨААТҮГ-ын дарга нь үйлдвэрийн газрынхаа хөрөнгө, түүний эх үүсвэрийг нэмэгдүүлэх, өмчийн ашиглалт, үр өгөөжийг дээшлүүлэх, өмчийн талаарх хариуцлага, ажилтан албан хаагчдын цалин хөлс, нэмэгдэл шагнал урамшууллын хэмжээг өөрчлөх асуудлаар Төлөөлөн удирдах Зөвлөл төсвийн ерөнхийлөн захирагчтай бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ байгуулж ажиллана”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг /цаашид "захирал" гэх/ томилохдоо гэрээ байгуулна, гэрээнд дараах нөхцөлийг тусгана” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Байгууллагын дүрмийн 5.3, 5.4, 5.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалтуудыг баримтлан, дээд шатны захирагчтай үр дүнгийн гэрээ байгуулж ажиллах

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5³-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Бараа материал хөрөнгийн ангиллаас 3,080.0 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгөд данс хооронд шилжүүлэхдээ орлогын дэлгэрэнгүй тайланд орлого дансаар дамжуулан бүртгэснийг өмнөх үеийн үр дүн дансаар бүртгэн	1	3,080.0			1	3,080.0	1	3,080.0				
Санхүүгийн байдлын тайланд өр төлбөрийг 5,860.5 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн	1	5,860.5	1	5,860.5			1	5,860.5				
Тайлант хугацааны дулааны төлбөрийн орлогыг 3,836.4 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан	1	3,836.4			1	3,836.4	1	3,836.4				
Санхүүгийн байдлын тайланд 939.4 мянган төгрөгийн авлагыг дутуу тусгасан	1	939.4			1	939.4	1	939.4				
Данснаас хассан хөрөнгийг элэгдлийн зардлаар бүртгэсэн	1	32,882.8			1	32,882.8	1	32,882.8				
Дүн	5	46,599.1	1	5,860.5	4	40,738.6	5	46,599.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Гэрээний алдангийг тооцоогүй	1	196.0	1	196.0								
Байгууллагын хөрөнгийг 707.2 мянган төгрөгийг ажилчдын хүүхдийн бэлэг худалдан	1	707.2	1	707.2								

авахад үр ашиггүй зарцуулсан												
Тэс оргил ХХК-аас өмнөх оны 4,215.8 мянган төгрөгийн авлага он дамжиж, тайлант онд 4,691.3 мянган төгрөгөөр нэмэгдэж нийт 8,907.1 мянган төгрөгийн авлагад тооцоо нийлж баталгаажуулаагүй	1	8,907.1			1	8,907.1						
Байгууллагын гэрчилгээ дээрх өмчийн дүн санхүүгийн тайлан дээрх өмчийн дүнгээс 16,068.7 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн	1	16,068.7					1	16,068.7				
Байгууллагын удирдлага нь дээд шатны удирдлагатай бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулаагүй, байгууллагын үр өгөөж, ашгийг дээшлүүлэхэд хариуцлагатай ажиллаагүй	1	-					1	-				
Дүн	5	25,879.0	2	903.2	1	8,907.1	2	16,068.7	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар												
Худалдан авах ажиллагааг төлөвлөгөөнд тусгаагүй 161,234.1 мянган төгрөгийн нүүрсийг шууд гэрээ байгуулан худалдан авсан	1	161,234.1			1	161,234.1						
Дүн	1	161,234.1			1	161,234.1			-	-	-	-